



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 259,600,000.00 (хоёр зуун тавин есөн сая зургаан зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 12,979,999.96 (арван хоёр сая есөн зуун далан есөн мянга есөн зуун ерэн есөн төгрөг ерэн зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг "Засгийн газрын автобааз" улсын төсөвт үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэг, "Засгийн газрын автобааз" улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал С.Энхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Б.ГАНБАТ

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



000003



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 1 дүгээр сарын 20 ны өдрийн
30 дугаар тогтоолын хавсралт

БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН

Д/д	Хөрөнгө шилжүүлэн өгөх байгууллага	Хөрөнгийн нэр, Улсын дугаар, Арлын дугаар	Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Шилжүүлэн авах байгууллага
						(төгрөг)			
1	Үндсэн хуулийн цэцийн Тамгын газар	Хьюндай Соната-Лф 03-75 УБЗ, КМНЕ241СВJA495068	2018	2018	6394	64,900,000.00	3,244,999.99	61,655,000.01	"Засгийн газрын автобааз" УТҮГ
2		Хьюндай Соната-Лф 02-97 УБЗ, КМНЕ241СВJA495073	2018	2018	7295	64,900,000.00	3,244,999.99	61,655,000.01	
3		Хьюндай Соната-Лф 00-43 УБЗ, КМНЕ241СВJA495109	2018	2018	3803	64,900,000.00	3,244,999.99	61,655,000.01	
4		Хьюндай Соната-Лф 07-04 УБЗ, КМНЕ241СВJA495071	2018	2018	6750	64,900,000.00	3,244,999.99	61,655,000.01	
НИЙТ ДҮН						259,600,000.00	12,979,999.96	246,620,000.04	
						(хоёр зуун тавин есөн сая зургаан зуун мянган	(арван хоёр сая есөн зуун далан есөн мянга есөн зуун ерэн есөн төгрөг ерэн зургаан мөнгө)	(хоёр зуун дөчин зургаан сая зургаан зуун хорин мянган төгрөг дөрвөн мөнгө)	